



ТӨРИЙН БҮХ ШАТНЫ
БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГАД

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2026. 01. 12 № 03/581
танай _____-ны № _____-т

Хамтран ажиллах тухай

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны 190 дугаартай тогтоолоор Авлигатай тэмцэх газрын гомдол, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаар 1-110 (нэг, нэг зуун арав) дугаар болж өөрчлөгдсөн.

Одоо ашиглаж буй 110 дугаарыг 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл давхар ашиглан, уг хугацаанаас хойш 1-110 дугаар ердийн горимоор ажиллах бөгөөд Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан чиг үүргийн хүрээнд авлигыг мэдээлэх шууд утас болох 1-110 дугаарыг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх, сурталчлах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Иймд өөрийн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны 190 дугаартай тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хамтран ажиллана уу. Үүнд

- Авлигыг мэдээлэх 110 тусгай дугаар 1-110 болж өөрчлөгдсөн талаар нийт албан хаагчдад мэдээлэх;

- Өөрийн байгууллагын цахим систем болон албан ёсны цахим хуудас, facebook хуудаст байршуулсан 110 тусгай дугаарыг 1-110 болгож өөрчлөх зэрэг болно.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

З.БААСАННЯМ



142603001184